



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БИОКОМБИНАТ ТӨХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/82/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261740 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Сүлд-Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Гүндбаяр Цахим хаяг: info@suld-audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
8. Аудитын илрүүлэлт	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага.....	16
8.4 Зөвлөмж.....	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ГШБ	Гэрээ шууд байгуулах
ЗГ	Засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/508
танай _____-ны № _____-т

БИОКОМБИНАТ ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ТЭСХУЯГ
ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 639.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант оны нийт орлогыг 6,325.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 6,325.1 сая төгрөгөөр, ашиг алдагдалгүй байхаар тогтоосон байна. Гүйцэтгэлээр 5,891.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,826.5 сая төгрөгийн зардал гарган, 64.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	262,005,008.48	1,240,767,042.46
1.1.4	Бусад авлага	878,056,457.87	671,431,376.06
1.1.6	Бараа материал	2,643,379,867.58	2,660,163,805.71
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,692,181.42	35,080.27
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,788,133,515.35	4,572,397,304.50
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,185,778,503.19	7,342,081,319.15
1.2.2	Биет бус хөрөнгө	4,601,068,480.00	4,616,380,480.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,786,846,983.19	11,958,461,799.15
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,574,980,498.54	16,530,859,103.65
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	173,006,356.59	60,799,612.28
2.1.1.3	Татварын өр	4,025,153.92	7,173,550.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	177,031,510.51	67,973,162.28
2.2	Өр төлбөрийн нийт дүн	177,031,510.51	67,973,162.28
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	2,141,020,492.31	2,141,020,492.31
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,944,423,800.98	8,944,423,800.98
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	4,601,068,480.00	4,601,068,480.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	711,436,214.74	776,373,168.08
2.3.11	Эздийн өмчийн дүн	16,397,948,988.03	16,462,885,941.37
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,574,980,498.54	16,530,859,103.65

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**/төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,894,619,771.97	5,783,789,103.57
2	Борлуулалтын өртөг		5,140,747,246.14
3	Нийт ашиг(алдагдал)	5,894,619,771.97	643,041,857.43
5	Хүүгийн орлого	5,433,080.87	
8	Бусад орлого	229,775,163.62	107,328,833.21
9	Борлуулалт, маркетингийн зардал	6,648,819,597.00	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	121,220,985.91	678,635,187.30
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	19,235,700.00	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(6,028,162.93)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(665,476,429.38)	71,735,503.34
19	Орлогын татварын зардал	543,308.09	7,173,550.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(666,019,737.47)	64,561,953.34
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(666,019,737.47)	64,561,953.34
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(666,019,737.47)	64,561,953.34
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	1,377,455,952.21	17,063,968,725.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	1,377,455,952.21	17,063,968,725.50
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(666,019,737.47)	(666,019,737.47)
7	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	711,436,214.74	16,397,948,988.03
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				375,000.00	375,000.00
9	Залруулсан үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	711,436,214.74	16,398,323,988.03
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				64,561,953.34	64,561,953.34
	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,141,020,492.31	8,944,423,800.98	4,601,068,480.00	776,373,168.08	16,462,885,941.37

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,959,844,787.38	5,911,781,074.87
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,959,798,023.38	5,820,169,029.20
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	46,764.00	
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого		91,612,045.67
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,899,641,857.41	4,763,730,752.89
	Ажиллагчдад төлсөн	2,620,584,073.92	2,062,264,175.88
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	362,768,764.15	646,764,874.58
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,660,786,396.62	891,134,506.80
	Ашиглалтын зардалд төлсөн	302,345,523.57	316,783,824.36
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	557,658,000.00	559,045,621.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	1,984,911.00	179,242,537.56
	Даатгалын төлбөрт төлсөн	11,373,380.90	
	Бусад мөнгөн зарлага	382,140,807.25	108,495,212.71
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(939,797,070.03)	1,148,050,321.98
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,433,080.87	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүгийн орлого	5,433,080.87	
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	127,140,611.00	169,288,288.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	127,140,611.00	153,448,288.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		15,840,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(121,707,530.13)	(169,288,288.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү	(6,028,162.93)	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,067,532,763.09)	978,762,033.98
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,329,537,771.57	262,005,008.48
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	262,005,008.48	1,240,767,042.46

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үндсэн үйлдвэрлэлийн орлого	мян.төг	5,894,619.7	6,225,098.7	5,783,789.1	(441,309.6)	92.9
2	Үйл ажиллагааны бусад орлого	мян.төг	235,211.2	100,000.0	107,328.8	7,328.8	107.3
3	Нийт орлого	мян.төг	6,129,830.9	6,325,098.7	5,891,117.9	(433,980.8)	93.1
4	Үйл ажиллагааны зардал	мян.төг	6,770,040.6	6,307,098.7	5,788,369.4	(518,729.3)	91.8
5	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	25,263.9	18,000.0	31,013.0	13,013.0	172.2
6	Нийт зардал	мян.төг	6,795,307.5	6,325,098.7	5,819,382.4	(505,716.3)	92.0
7	Татварын өмнөх ашиг алдагдал	мян.төг	(665,476.4)	0.0	71,735.5	71,735.5	100.0
8	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	(666,019.7)	0.0	64,561.9	64,561.9	100.0
10	Хөрөнгө оруулалт, их засвар	мян.төг	85,000.0	268,000.0	198,000.0	(70,000.0)	73.9
11	Нийт өр төлбөр	мян.төг	177,031.5	153,770.4	67,973.2	(85,797.2)	55.8
12	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	177,031.5	153,770.4	67,973.2	(85,797.2)	55.8
13	Нийт авлага	мян.төг	878,056.5	878,056.5	671,431.4	(206,625.1)	76.5
14	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.11	1	0.99	(0.0)	99.0
15	Цалингийн сан	мян.төг	2,743,457.3	2,500,000.0	2,504,200.0	4.2	100.2
16	Ажилчдын тоо	хүн	254	254	251	(3.0)	98.8
17	Нэг ажилтны жилийн дундаж цалин	мян.төг	10,801.0	9,842.5	958.5	0.1	101.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад компанийн засаглал, зардлын төлөвлөлт, цалингийн тооцооллыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 03-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Б.Долгорсүрэн, туслах аудитор Б.Баттогтох нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер С.Лхагважав, захирал Ч.Гүндбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Сүлд-Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитор нь ТУЗ-ийн нарийн бичгийн албан тушаалыг хавсран гүйцэтгэж байгаа нь ашиг сонирхлын зөрчлийг бий болгосон байна. Мөн тайлант хугацаанд санхүүгийн дотоод аудитор нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг гүйцэтгээгүй байгаагаас дотоод хяналтын үйл ажиллагааг хангалтгүй гэж дүгнэв.

Тус компанийн мөрдөж байгаа НБББББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангаас нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 6,795.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 67.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Биокомбинат ТӨХХК-ийн зорилго нь шинжлэх ухаанд суурилсан малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх оношлох, эмчлэх био бэлдмэлийг үйлдвэрлэж чанарын баталгаатай бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг хангах, хамтын хөгжлийг дээдлэгч мал эмнэлгийн тэргүүлэх салбар болоход оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг өндөр идэвхтэй био бэлдмэл, оношлуурыг үйлдвэрлэн хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр хангах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчит статустай байна. Өмчийн 100 хувийг төр, үүнээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам 100 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Биокомбинат ТӨХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 237 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.7 “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;...” гэсэн заалттай нийцэж байна.

Биокомбинат ТӨХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд ашигт ажиллагааг сайжруулах зорилгоор импортоор оруулж ирж буй малын шүлхий вакциныг өөрсдөө үйлдвэрлэвэл ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар судалгаа хийж нэвтрүүлэх ажлыг 2022 оны төлөвлөгөөнд оруулан батлуулсан байна.

ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг

үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулан батлаагүй ч, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай
- Биокомбинат ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 8 дугаар тогтоолоор “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн баталсан.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Биокомбинат ТӨХХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	262,005.0	1,240,767.0	978,762.0
Авлага	878,056.4	671,431.4	(206,625.0)
Урьдчилгаа	4,692.2	35.1	(4,657.1)
Бараа материал	2,643,379.9	2,660,163.8	16,783.9
Үндсэн хөрөнгө	8,185,778.5	7,342,081.3	(843,697.2)
Биет бус хөрөнгө	4,601,068.5	4,616,380.5	15,312.0
Нийт хөрөнгийн дүн	16,574,980.5	16,530,859.1	(44,121.4)
Өр төлбөрийн дүн	177,031.5	67,973.2	(109,058.3)
Эздийн өмч	16,397,949.0	16,462,885.9	67,973.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,574,980.5	16,530,859.1	(44,121.4)

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.6 сая төгрөг, харилцах дансанд 1,240.2 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Тайлант онд дансны авлага 671.4 сая төгрөг болж 206.6 сая төгрөгөөр буурсан нь харилцагчдаас авах авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,660.2 сая төгрөг болж 16.8 сая төгрөгөөр өссөн нь түүхий эд материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,342.1 сая төгрөг болж 843.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардлаас шалтгаалсан байна. Тайланд онд өөрийн хөрөнгөөр 179.1 сая төгрөгийн хөрөнгө олж бэлтгэсэн байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 4,616.4 сая төгрөг болж 15.3 сая төгрөгөөр өссөн нь санхүүгийн программ хангамж худалдан авч түүний тайлант хугацааны элэгдлийг байгуулснаас шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 729 нэр төрлийн 3,179.8 сая төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг байгууллага ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд бэлтгэн нийлүүлэгчид төлөх 60.8 сая төгрөгийн өр төлбөр болон татварын албанд төлөх 7.2 сая төгрөгийн өглөг байна. Өр

төлбөр дансны үлдэгдэл 68.0 сая төгрөг болж 109.0 сая төгрөгөөр буурсан нь бэлтгэн нийлүүлэгчид төлөх барааны төлбөр төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын НБББББ-т орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг орлого, зардал зохицох зарчмын дагуу гарсан зардал болон өртгийг түүнтэй холбоотой орлогод шууд хамааруулах үндсэн дээр тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 505.7 сая төгрөгөөр буурсан нь ковид-19 цар тахлын улмаас хил гааль хаагдсанаас худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан ажлууд хийгдээгүйтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 16,462.9 сая төгрөг болж 64.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

ТБОНӨТХ-ийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК нь байгууллагынхаа үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Биокомбинат ТӨХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 6 дугаар тогтоолоор Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 6,325.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 6,325.1 сая төгрөгөөр, ашиг алдагдалгүй байхаар тогтоосон байна. Мөн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 268.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 5,891.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5,826.5 сая төгрөгийн зардал гарган, 64.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 5,891.1 сая төгрөг болж төлөвлөснөөс 434.0 сая төгрөг буюу 6.9 хувиар тасарсан нь ковид-19 цар тахлаас шалтгаалан хил гааль хаагдаж түүнээс шалтгаалан түүхийн эдийн нийлүүлэлт удааширсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 5,826.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 505.7 сая төгрөг буюу 7.9 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь ковид-19 цар тахлаас шалтгаалан хил гааль хаагдсанаас түүхийн эдийн нийлүүлэлт удааширсан нь гол нөлөө үзүүлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 12 нэр төрлийн 1 ажилд өөрийн эх үүсвэрээс 198.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг төлөвлөснөөс 64.6 сая төгрөгөөр илүү байгаа нь тайлант оны худалдан авалт бүрэн хийгдээгүйтэй холбоотой байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд нийт 9,322.7 сая төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 174.8 сая төгрөгийн 26 мэдээллийг ил тод байршуулаагүй, 65 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд худалдан авах ажиллагааны хуулийн дагуу нийт 2,235.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн бөгөөд нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар 1,622.6 сая төгрөгийн 9 худалдан авалт, харьцуулалтын аргаар 176.8 сая төгрөгийн 8 худалдан авалт, шууд худалдан авалтаар 436.3 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

1. Гэрээ шууд байгуулах нөхцлөөр Цэцүүх ХХК-тай 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 198.7 сая төгрөгийн өртөгтэй Биологийн үйлдвэрлэлд хэрэглэгдэх савлагааны тоног төхөөрөмж худалдан авах гэрээг байгуулсан байна. Тус гэрээний төлбөр 200.0 сая төгрөгийг 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдөр аль хэдийн гэрээ байгуулахаас өмнө шилжүүлж, тоног төхөөрөмжийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор нийлүүлэх байсан ч ковид-19 цар тахлаас шалтгаалан хил гаалийн асуудал удаашралтай байгаа тул одоог хүртэл барааг хүлээн аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил үйлчилгээг бэлтгэхдээ худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, гэрээнд заасан үүргийн биелэлтийг хангуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомжийн холбогдох шалгуурт тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар 1,251.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 1,077.3 сая төгрөгийн алдааг залруулж, 171.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснөөс 3.2 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжээгүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,091.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 160.9 сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж өгснөөс акт 100.0 хувь, албан шаардлага 55.1 хувь, зөвлөмж 94.5 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	0.6	1	0.6	-	-	100.0
Албан шаардлага	2	1,091.4	1	601.5	1	489.9	55.1
Зөвлөмж	10	160.9	8	152.0	2	8.9	94.5
Нийт дүн	12	1,252.9	10	754.1	3	498.8	83.2

/мянган төгрөгөөр/

Шилэн дансны хуулийн хэрэгжилт, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2 зөрчил давтан гарсанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шатахуун зарцуулалтыг батлагдсан норм, стандартын дагуу тооцон олгож байгаа эсэхэд биет тест хэрэгжүүлэх мөн бүтээгдэхүүний өртгийн тооцоог шалгах нь зүйтэй гэж үзэв.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 639.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 6.1 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 127.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 506.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 15 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 639.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 67.9 сая төгрөгөөс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.2 Төлбөрийн акт

1. Ажилтнаас сахилгын шийтгэлийн 0.3 сая төгрөгийг суутгаагүйгээс цалин илүү олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"*, 20.2.5-т *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2.Цехийн эрхлэгчид 0.2 сая төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т *"Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ"*, 20.2.3-т *"холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"*, 20.2.5-т *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"* заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.Санхүүгийн дотоод аудитор нь ТУЗ-ийн 9 дүгээр тогтоолын дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар 2021 оны 10 дугаар сараас томилогдсон бөгөөд тус ажилтанд гүйцэтгэх захирлын тушаал болон ТУЗ-ийн тогтоолын дагуу албан тушаал бүрд үндсэн цалингийн хэмжээгээр цалинг тооцон нийтдээ 2.5 сая төгрөгийн цалин илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1. *"Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно"*, 28.2 *"Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна"* гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.Тайлант онд зочин төлөөлөгч хүлээн авах, тэмцээн зохион байгуулахад нийтдээ 3.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1 “төсвийг үр ашигтай,хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1. “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах, төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

1.Санхүүгийн тайланд тусгагдсан 118.9 сая төгрөгийн авлага, 2.4 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, ТБОНӨТХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” заалттай нийцэхгүй,санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2.Тус байгууллагын санхүүгийн дотоод аудитор нь гүйцэтгэх захирлын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Б/02 тушаалаар санхүүгийн дотоод аудитор, ТУЗ-ийн 9 дүгээр тогтоолоор 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар тус тус томилогдсон. Энэ нь компанийн засаглалын хувьд ашиг сонирхлын зөрчлийг бий болгож байгаа бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно”, СЗХ-ны даргын 2013 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан “ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үлгэрчилсэн журам” 2.4 “Нарийн бичгийн даргыг тухайн компанид өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.Тайлант онд эх үрсийн баярыг тэмдэглэн ажилчдын хүүхдийн бэлгэнд 5.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1 “төсвийг үр ашигтай,хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1. “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Компанийн засаглалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 237 дугаар тогтоолын дагуу ТӨХХК болон өөрчлөн зохион байгуулагдаж, гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон

гүйцэтгэгчийг томилсон боловч гэрээ, контракт байгуулан ажиллаагүй нь ТБОНӨТХ-ийн 19 дүгээр зүйл 1. “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төлөөлөн удирдах зөвлөлтэй гэрээ, контракт байгуулан ажиллаж ажлын үр дүнг тооцуулж байх;

2.Программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

НБББББ-т заасны дагуу дансны кодчиллыг санхүүгийн программд тайлагнаагүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцохдоо үндсэн хөрөнгийг ашиглах жилийг баримталдаггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2.”аж ахуйн нэгж, байгууллагын НБББББ-ийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НБББББ-т заасны дагуу үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тооцох, санхүүгийн программ хангамжид шинэчлэлт хийж ажиллах.

3.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 730 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь НББОУС 16 “Үндсэн хөрөнгө”-ийн 31.”Тайлагналын үеийн эцэс дэх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг ханган магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТӨБЗГ-т хандан цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдийг дахин үнэлүүлж, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлуулан данс бүртгэлээс хасуулах;

4.Өртөг, зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардалд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгосон 10.6 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг бүртгэж тайлагнасан байгаа нь НББОУС 2 “Бараа материал” 12.“Үйлдвэрлэлийн хувьсах нэмэгдэл зардал нь үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс шууд эсвэл ойролцоогоор шууд хамааран өөрчлөгддөг шууд бус хөдөлмөр, шууд бус материал гэх мэт үйлдвэрлэлийн шууд бус зардал байна” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

НБББББ-т заасны дагуу өртөг зардлыг хуваарилан бүртгэж, санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнах;

5.Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд ТУЗ-ийн үйл ажиллагаанд зардал батлаагүй боловч гүйцэтгэлээр 2.0 сая төгрөгийн зардал гаргасан нь ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.3 “захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн

16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, ТУЗ-н үйл ажиллагааны зардлыг зардлын төлөвлөгөөнд оруулан батлуулж байх;

6.Татварын үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Татварын албатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс ХХОАТ-ын өглөг санхүүгийн тайланд 0.1 сая төгрөгөөр дутуу тусгагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын албатай үлдэгдлийг тооцоо нийлэн баталгаажуулж, зөрүүг арилгах;

7.Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүү байдлын тайланд Цэцүүх ХХК-ийн авлага 272.8 сая төгрөг, өглөг 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнагдсан. Цэцүүх ХХК-д илгээсэн сөрөг тулган баталгаажуулах захидалд 272.8 сая төгрөгийн авлагатай гэж тусгасан боловч өглөг 0.5 сая төгрөг нь нотлогдохгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлан гаргахаас өмнө ажил гүйлгээг нягталж, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх;

8.Татварын хөнгөлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны жилийн эцэст ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцооллыг нэгтгэж тооцоогүйгээс зарим ажилчдад 0.1 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу тооцож, ТУЗ-ийн гишүүдэд 0.7 сая төгрөгийн илүү хөнгөлөлт тооцсон байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1."Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ХХОАТ-ын хөнгөлөлтийг жилийн эцэст нэгтгэн тооцоолж, татварыг үнэн зөв тайлагнаж байх;

9.Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

НДШ-ийн тайлангаарх ажилчдын цалинг хүн тус бүрээр нь олгохоор тооцсон цалингийн дүнтэй тулган баталгаажуулахад нийгмийн даатгалын тайланд 0.5 сая төгрөгийн цалин илүү тайлагнагдаж, үүнтэй холбоотойгоор 0.4 сая төгрөгийн шимтгэлийг дутуу, 0.1 сая төгрөгийн шимтгэлийг илүү тайлагнасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1 "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалд илүү дутуу тайлагнасан шимтгэлийг дараа сарын тайланд залруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

10.Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Захирлын тушаалын дагуу нэмэгдлийг тооцож олгоогүйгээс ажилтанд 0.2 сая төгрөгийн цалин дутуу олгогдсон, мөн цалингийн шатлалын дагуу цалин хөлсийг тогтоогоогүйгээс ажилтанд 0.1 сая төгрөгийн цалин дутуу олгосон байна. Энэ нь ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.10 "Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тушаалын дагуу дутуу олгосон цалинг нөхөн тооцож олгон холбогдох татвар шимтгэлийг тайлагнах,

11.Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Биокомбинат ТӨХХК-ийн хөдөлмөрийн дотоод журамд зааснаар сахилгын шийтгэл ногдуулсан ажилтны үндсэн цалинг 1-3 хүртэлх сарын хугацаатайгаар 20.0 хувиар бууруулах журамтай боловч сахилгын шийтгэлийг ажилтны үндсэн цалинг бууруулахгүй гарт олгох дүнгээс суутган тооцоноос шалтгаалан байгууллагын төлөх НДШ-ийн хэмжээ 0.4 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цалин хөлсийг үнэн зөв тооцож ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

12.Хоолны суутгалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан томилолтоор ажиллаж байх хугацаанд 0.1 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2 "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ", 2.2.1 "унааны зардал", 2.2.2 "байрны зардал" 2.2.3 "хоолны зардал" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "үнэлгээ ба хэмжилт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Албан томилолтын тооцоог цаг тухайд нь хийж байх, томилолтоор ажилласан хоногийг хүний нөөцтэй тулгалт хийж хоолны хөнгөлөлтийг зөв тооцон олгож байх;

13.Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мал эмнэлгийн хүрээлэнд 0.5 сая төгрөгийн мөнгөн тусламж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

14.Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төлбөрийн и баримтгүйгээр 489.9 сая төгрөгийн бараа худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.3.2,17.6 заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт бүрийг төлбөрийн и баримтаар баталгаажуулан ажиллах, сар бүрийн эцэст худалдан авалтыг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэн бичигдээгүй төлбөрийн и баримтыг нөхөн авч байх;

15.Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хувь хүнээр гүйцэтгүүлсэн 1.9 сая төгрөгийн ажлын хөлснөөс 0.2 сая төгрөгийн НДШ суутган тооцолгүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.7."аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажлын хөлснөөс НДШ суутган тооцож тайлагнаж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу тухайн ажилтнаас сахилгын шийтгэлийг суутгаагүйгээс цалин илүү олгосон	Илүү олгосон цалинг буцаан суутган авч улсын төсөвт төвлөрүүлэх	1	267.6			1	267.6						
2	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Цехийн эрхлэгчид 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох байсныг давтан тооцоолоход 243.1 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон байна.	Илүү олгосон тэтгэмжийг суутган авч улсын төсөвт төвлөрүүлэх	1	243.1			1	243.1						
3	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Санхүүгийн дотоод аудитор Б.Оюунцэцэг нь ТУЗ-ийн 9 дүгээр тогтоолын дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар 2021 оны 10 сараас томилогдсон бөгөөд тус ажилтанд гүйцэтгэх захирлын тушаал болон ТУЗ-н тогтоолын дагуу албан тушаал бүрт үндсэн цалингийн хэмжээгээр цалинг тооцон олгожээ	Илүү олгосон цалинг төлүүлэх	1	2,460.0			1	2,460.0						
4	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	ЗГ-н 43 тогтоол зөрчиж 3,122.3 мянган төгрөгийн зардал гаргасан.	Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	1	3,122.3			1	3,122.3						
5	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	ЗГ-н 43 тогтоол зөрчиж 5,900.0 мянган төгрөгийн эх үрсийн баяр тэмдэглэх зардал гаргасан.	Алдаа зөрчил давтан гаргахгүй байх	1	5,900.0					1	5,900.0				

Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Өмнөх оны аудитын зөвлөмжийг биелүүлэлгүй санхүүгийн тайланд тусгагдсан 118,891.6 мянган төгрөгийн авлага, 2,422.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Авлага өглөгийн тооцоо нийлэлтийг хийж үлдэгдлийг баталгаажуулах	1	121,314.1							1	121,314.1				
7	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Тус байгууллагын санхүүгийн дотоод аудитор нь гүйцэтгэх захирлын 2021 оны 07 сарын 09-ний өдөр Б/02 тушаалаар санхүүгийн дотоод аудитор, ТУЗ-ийн 9 дүгээр тогтоолоор 2021 оны 10 сарын 04-ний өдрөөс ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар тус тус томилогдсон. Энэ нь компанийн засаглалын хувьд ашиг сонирхлын зөрчлийг бий болгож байна.	Ажил үүргийн давхардлыг арилгах	1	0.0							1	0.0				
8	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Төлбөрийн И баримтгүйгээр бараа худалдан авсан байна.	Худалдан авалт бүрт төлбөрийн и баримтыг авч байх	1	489,889.8											1	489,889.8
9	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Татварын албатай тооцоо нийлж үлдэгдлээ баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан ХХОАТ-ын өглөг татварын тайлангийн үлдэгдлээс дутуу туссан байна.	Татварын албатай тооцоо нийлэн үлдэгдлийг баталгаажуулж зөрүүг арилгах	1	90.0											1	90.0
10	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Хувь хүнээр гүйцэтгүүлсэн ажлын хөлснөөс НДШ суутган тооцолгүй олгосон	НДШ суутган тайлагнах	1	223.6											1	223.6
11	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон боловч гэрээ, контракт байгуулан ажиллаагүй байна.	Гэрээ, контракт байгуулах	1	0.0											1	0.0
12	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Дансны кодчиллыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгасны дагуу санхүүгийн программд тусгаагүй, мөн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцохдоо НБББББ-т тусгасан үндсэн хөрөнгийг ашиглах жилийг баримталдаггүй байна.	Программ хангамжид өөрчлөлт оруулах	1	0.0											1	0.0
13	Биокомбинат ТӨХХК	АХГ-2022/82/НА-СТА-ТӨА	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны	ТӨБЗГ хандан асуудлыг шийдвэрлүүлэх	1.	0.0											1	0.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 99/АД15045Р

Улаанбаатар хот

НХТ-2022/02/НА-СТА-76А

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цехийн эрхлэгчид 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгоходоо үндсэн цалингийн хэмжээг буруу тооцоноос шалтгаалан 243,090.00 төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон тэтгэмжийн 243,090.00 /хоёр зуун дөчин гурван мянга ерэн/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Ч.ГҮНДБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 98/АД150458

Улаанбаатар хот

АХТ-2022/02/НА-СТА-ТБА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 9 дүгээр тогтоолын дагуу санхүүгийн дотоод аудиторыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар 2021 оны 10 сараас томилж, тус ажилтанд гүйцэтгэх захирлын тушаал болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу албан тушаал бүрд үндсэн цалингийн хэмжээгээр цалинг тооцон 2,460,000.00 төгрөгийн цалинг илүү олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 "Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно", 28.2 "Энэ хуулийн 28.1 нь хавсран ажиллахад нэгэн адил хамаарна" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Илүү олгосон цалингийн 2,460,000.00 /хоёр сая дөрвөн зуун жаран мянга/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Ч.ГҮНДБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 99/А0150458

Улаанбаатар хот

АХТ-2022/82/НА-СТА-ТБА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд зочин төлөөлөгч хүлээн авах, тэмцээн зохион байгуулахад нийтдээ 3,122,300.00 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.3 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үр ашиггүй зарцуулсан 3,122,300.00 /гурван сая нэг зуун хорин хоёр мянга гурван зуун/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.ГҮНДБАЯР

9006109
9019130396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

©10.10.20/Bichig_Khereg/Akt-2022/0315 Auditin 2 Газар-38 Docx

0001090247



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 110/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/82/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилтнаас сахилгын шийтгэлийн 267,580.97 төгрөгийг суутгаагүйгээс цалин илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Сахилгын шийтгэлийн суутгаагүй 267,580.97 /хоёр зуун жаран долоон мянга таван зуун наян/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Ч.ГҮНДБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 452/А0150458
АХГ-2022/82/НА-СТА-Т6А

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээ шууд байгуулах нөхцөлөөр Цэцүүх ХХК-тай 2020 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 198,700,000.00 төгрөгийн өртөгтэй Биологийн үйлдвэрлэлд хэрэглэгдэх савлагааны тоног төхөөрөмж худалдан авах гэрээг байгуулсан байна. Тус гэрээний төлбөр 200,000,000.00 төгрөгийг 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдөр гэрээ байгуулахаас өмнө шилжүүлж, тоног төхөөрөмжийг 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор нийлүүлэх байсан ч ковид-19 цар тахлаас шалтгаалан хил гаалийн асуудал удаашралтай байгаа тул одоог хүртэл барааг хүлээн аваагүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйл 34.2. "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил үйлчилгээг бэлтгэхдээ худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, гэрээнд заасан үүргийн биелэлтийг хангуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.ГҮНДБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага туйруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-128.Docx

001081254



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 дугаар сарын 15 № 450/АД150458
АХТ-2022/02/НА-СТА-ТБА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хүүхдийн баярыг тэмдэглэн, ажилчдын хүүхдийн бэлгийн зардалд 5,900,000.00 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүрэг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.ГҮНДБАЯР



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-124.Docx

001081248



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 451/АМ150458
АХГ-2022/82/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 174,760,695.58 төгрөгийн ажил, гүйлгээний 26 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,397,841,597.00 төгрөгийн ажил, гүйлгээний 65 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд, ил тод, бүрэн байршуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Ч.ГҮНДБАЯР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 453/А0150458
АХТ-2022/82/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгасан 118,891,612.76 төгрөгийн авлага, 2,422,559.20 төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагчидтай авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлэн баталгаажуулж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биокомбинат ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэгч Б.Цэвэлсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Ч.ГҮНДБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 454/АО150458
АХГ-2022/82/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Биокомбинат ТӨХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын санхүүгийн дотоод аудитор нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 9 дүгээр тогтоолоор 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдсон.

Энэ нь компанийн засаглалын хувьд ашиг сонирхлын зөрчлийг бий болгож байгаа бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно", Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргын үлгэрчилсэн журмын 2.4 "Нарийн бичгийн даргыг тухайн компанид өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгэхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ашиг сонирхлын зөрчил үүсэж буй нөхцөлийг арилгах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биокомбинат ТӨХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Т.Жамбалцэрэн, гүйцэтгэх захирлын албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч С.Тэсхуяг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
СҮЛД-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.ГҮНДБАЯР

